Эдийн засаг, хөгжлийн яам

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2024 оны 10 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ

ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ-ий өсөлт
(2024 оны эхний 3 улирал)

5.0 хувь

Валютын нөөц
(2024 оны 10 дугаар сар)

4,701 сая $

Инфляц
(2024 оны 10 дугаар сар)

7.0 хувь

Төсвийн тэнцэл
(2024 оны 10 дугаар сар)

1.5 их наяд ₮

Экспорт
(2024 оны 10 дугаар сар)

13.2 тэрбум $

Импорт
(2024 оны 10 дугаар сар)

9.6 тэрбум $

ГШХО
(2024 оны эхний хагас)

2,070 сая $

Зээлийн хүү
(2024 оны 10 дугаар сар)

17.0 хувь

Ажилчдын тоо
(2024 оны 3 дугаар улирал)

1.4 сая

*III улирлын байдлаар ажиллах хүчний оролцоо нь түвшин 63 хувь байна.

Бодит цалингийн өсөлт
(2024 оны 2 дугаар улирал)

23.6 хувь

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ
(2024 оны 3 дугаар улирал)

104.6 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт
(2024 оны 3 дугаар улирал)

10.0 хувь

1.1 ДНБ

2024 оны 3 дугаар улирал

Эдийн засгийн өсөлт 2024 оны эхний 3 улирлын байдлаар 5.0 хувь байна. Худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил нэмэгдэж, татварын орлого сайн байсан нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж байна. Харин боловсруулах болон барилгын салбарын өсөлт саарч, хөдөө аж ахуйн салбарын уналт өсөлтийг хязгаарлав.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
(2024 оны эхний 3 улирал)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛ УУРХАЙ
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨДӨӨ АЖ АХУЙ
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2024 оны эхний 3 улиралд **5.0 хувиар өслөө.**
- Анхдагч салбар: Уул уурхайн салбар 11.4 хувиар тэлж, өсөлтийн 1.4 хувийг бүрдүүлсэн бол ХАА-н салбар 25.0 хувиар агшиж, нийт өсөлтийг -3.5 нэгж хувиар хязгаарлалаа.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 2.6 хувиар өсөж өсөлтийн 0.3 нэгж хувийг;
- Үйлчилгээний салбар /худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 9.6 хувиар өсөж өсөлтийн 4.6 хувийг ;
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 14.6 хувиар өсөж өсөлтийн 2.1 хувийг тус тус бүрдүүлсэн байна.

- 2024 оны 3 дугаар улиралд худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт сайн байж, татварын орлого нэмэгдсэн нь өсөлтөд эергээр нөлөөлж байна.
- Уул уурхайн салбарын нийт эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө өмнөх жилийн өндөр суурийн нөлөөгөөр буурч байна.
- Харин том малын зүй бус хорогдол оны эхнээс нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбар агшив.

- Уул уурхайн салбар 2024 оны эхний 3 улиралд 11.4 хувиар тэллээ.
- Нүүрс, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал зэсийн баяжмал зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн олборлолт нэмэгдсэнээр уул уурхайн салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөллөө. *(9 дүгээр сарын уул уурхайн бүтээгдэхүүний олборлолтын талаар энд эх харна уу.)*

- ХАА-н салбар 2024 оны эхний 3 улиралд 25.0 хувиар агшлаа.
- Том малын зүй бус хорогдол 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 8.1 сая толгойд хүрч өмнөх оны мөн үеэс 4.2 сая толгой малаар нэмж хорогдсон байна. Энэ нь оны эхний *(2023 оны 12 сард эцэслэсэн нийт малын тоо нь 2024 оны эхэнд байгаа нийт малын тоо болно.)* нийт малын 12.6 хувьд хүрч хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл жил дараалан буурлаа.
- Нийт тариалсан талбай өнгөрсөн оноос 1.4 хувиар, хураасан улаан буудай 7.8 хувиар тус тус буурлаа.

1.2 ДНБ: Эрэлт

2024 оны 3 дугаар улирал

Дотоод эдийн засгийн идэвхжил нийт эдийн засгийн өсөлтийг тэтгэж байна.

ДНБ ӨСӨЛТИЙН БҮТЭЦ
(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Төрийн болон өрхийн хэрэглээ эдийн засгийн өсөлтийг голлон тайлбарлаж байна.
- Импортын эрчимтэй өсөлт цэвэр экспортыг бууруулж, өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалинг нэмснээр төсвийн цалингийн зардал 2.4 дахин нэмэгдэн төрийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 37.7 хувиар өсөв.
- Цалин, тэтгэвэр тэтгэмжийн өссөний зэрэгцээ хэрэглээний зээл олголт эрчимжсэн нь өрхийн хэрэглээний 14.3 хувиар өсөлтийг дэмжив.

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН БҮТЭЦ *(жилийн өсөлтийн хувь)*



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үндсэн хөрөнгийн хуримтлал 7.2 хувиар өсөв.
- Уул уурхайн хүнд машин механизмын хуримтлал болон авто зам зэрэг инженерийн барилга байгууламжийн бүтээн байгуулалтууд өсөлтөд голлох хувь нэмрийг оруулсан байна.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Хэдийгээр нүүрсний экспортын тоо хэмжээ өссөн ч үнэ буурсан нь экспортын орлого 2.8 хувиар буурахад нөлөөлөв.
- Хэрэглээ, хөрөнгө оруулалтыг даган бараа, үйлчилгээний импорт өмнөх оны мөн үеэс 19.3 хувиар өсөв.

1.3 АЖ ҮЙЛДВЭР

2024.10 сар

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 10 сард 7.9 хувиар өсөв. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн олборлолт уул уурхайн салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөлж байгаа бол мах, гурил, нэхмэл үйлдвэрлэл буурснаар боловсруулах салбарын үйлдвэрлэл уналттай байна.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(тэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(тэрбум төгрөг, ҮҮИ-ээр засварласан бодит дүн)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, ҮСХ

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

(голлох бүтээгдэхүүнээр)

		өмнөх оноос өөрчлөлт:
Нүүрс	**81.1** *сая тонн*	26%
Зэсийн баяжмал	**1,257** *мянг.тонн*	7.8%
Газрын тос	**3.5** *сая баррель*	-15%
Алт	**11.0** *тонн*	-12%
Төмрийн хүдэр	**8.3** *сая тонн*	25%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС *(2015=100)*



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2024 оны эхний 10 сард 26.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар өслөө.
- Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн олборлолт нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 10.3 хувиар нэмэгдэж байна.
- Боловсруулах салбарын үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэрлэсэн дүнгээр 0.1 хувиар буурлаа.

- Тус салбарын бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) 2024 оны эхний 9 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.8 хувиар өсөөд байна. Үүнд:
- Салбарын дийлэнхийг эзэлдэг уул уурхайн салбарын үйлдвэрлэл бодит дүнгээр 3.8 хувийн өсөлттэй байна.
- Мах боловсруулалт, гурил, ээрэх нэхэх үйлдвэрлэл буурснаар нийт боловсруулах үйлдвэрлэл бодит дүнгээр буурсан үзүүлэлттэй байна.

- Нүүрс олборлолт 2024 оны эхний 10 сард 81.1 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 26 хувиар нэмэгдээд байна.
- Төмрийн хүдэр, баяжмал олборлолт өмнөх оны мөн үеэс сэргэж 25 хувиар өсөөд байна.
- Зэсийн баяжмал үйлдвэрлэл 7.8 хувиар өсөж 1,256 мянган тоннд хүрсэн байна. Үүнд Оюутолгойн зэсийн баяжмал үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлөв.
- Харин алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс буурсан хэвээр байна.

Үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар, цар тахлын өмнөх үеэс 54 хувиар өслөө. Үнийн индексийг бүрэлдэхүүнээр харвал:

<u>Үнэ өссөн:</u>

- Уул уурхай, олборлолт 1.2 хувиар;
- Хүнсний бүтээгдэхүүн 5.8 хувиар;
- Ундаа, согтуурууулах ундаа 9.4 хувиар,
- Нэхмэлийн үйлдвэрлэлийнх 0.6 хувиар тус тус өссөн бол

<u>Үнэ буурсан:</u>

- Кокс болон газрын тос боловсруулах үйлдвэрлэлийнх 0.8 хувиар
- Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн үнэ 10 хувиар буурав.

1.4 БОЛОВСРУУЛАХ САЛБАР

2024.10 сар

Боловсруулах салбарын үйлдвэрлэл 2024 оны эхний 10 сард нэрлэсэн дүнгээр 0.1 хувиар, үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүнгээр 7 хувиар буурлаа. Үүнд боловсруулах салбарын 15 орчим хувийг бүрдүүлдэг, хөдөө аж ахуйн гаралтай мах, нэхмэл эдлэлийн үйлдвэрлэлийн биет хэмжээний бууралт голлон нөлөөллөө.

МАХ
(мян. тонн)



Эх сурвалж: ҮСХ

- Боловсруулсан малын мах 2024 оны эхний 10 сард 27 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 15 хувиар буурлаа.
- Малын мах боловсруулалтын биет хэмжээ буурсан нь боловсруулах салбарын 8 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 37 хувиар буурахад голлон нөлөөллөө.

ГУРИЛ
(мян. тонн)



Эх сурвалж: ҮСХ

- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2024 оны эхний 10 сард 115.7 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 23 хувиар буурлаа.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ буурснаар боловсруулах салбарын 7 орчим хувийг бүрдүүлдэг гурил болон гурилан бүтээгдэхүүний бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 25.7 хувиар буурахад голлох нөлөө үзүүллээ.

УНДАА
(мян. тонн)



Эх сурвалж: ҮСХ

- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2024 оны эхний 10 сард 490 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 8 хувиар өслөө.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ өссөнөөр боловсруулах салбарын 24 хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар өсөж боловсруулах салбарын өсөлтийг дэмжиж байна.

НООЛУУРАН СҮЛЖМЭЛ ЭДЛЭЛ
(мян. ширхэг)



Эх сурвалж: ҮСХ

- Ноолууран сүлжмэл эдлэлийн биет хэмжээ 2024 оны эхний 10 сард 293 мянган ширхэг болж, өмнөх оны мөн үеэс 17 хувиар буурлаа.
- Ноолууран сүлжмэл эдлэлийн тоо ширхэг буурснаар боловсруулах салбарын 7 орчим хувийг бүрдүүлдэг нэхмэлийн бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 33 хувиар буурахад голлох нөлөө үзүүллээ.

1.5 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР

2024.09-10 сар

Үйлчилгээний салбарт худалдаа, зочид буудал, нийтийн хоол зэрэг салбаруудын идэвх сайн байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын нөлөөгөөр тээврийн салбарын ачаа тээвэр өсөлттэй байна.

ХУДАЛДАА

(салбарын орлого, тэрбум төгрөг, ХҮИ-ээр засварласан бодит дүн)



Тэмдэглэл: Тус салбаруудын статистик нь 45 хоногийн хоцрогдолтой зарлагддаг.

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, ҮСХ

- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар эзэлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2024 оны эхний 9 сард нэрлэсэн дүнгээр 48 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 16 хувиар өссөн байна. Харин үнийн нөлөөг засварласан бодит орлогын дүн 9.2 хувийн өсөлттэй байна.

ЗОЧИД БУУДАЛ, ХООЛ

(салбарын орлого, тэрбум төгрөг, ХҮИ-ээр засварласан бодит дүн)

Тэмдэглэл: Тус салбаруудын статистик нь 45 хоногийн хоцрогдолтой зарлагддаг.

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, ҮСХ

- Зочид буудал, нийтийн хоолны салбарын борлуулалт 2024 оны эхний 9 сард бодит дүнгээр 28 болон 20 хувиар тус тус өссөн байна.

ТЭЭВЭР

(тээсэн ачаа, сая тонн)

	2023.09	2024.09
НИЙТ	**72.6**	**87.5**
Төмөр зам	23.8	24.5
Уул уурхайн бүт.	15.0	15.5
Авто зам	48.8	63.0
Уул уурхайн бүт.	46.8	59.5
Агаар	0.01	0.01

Тэмдэглэл: Авто замын тээврийн статистик нь улирлаар зарлагддаг.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Тээврийн салбарт 2024 оны эхний 9 сарын байдлаар 87.5 сая ачаа тээвэрлэж, өмнөх оны мөн үеэс 21 хувиар өссөн байна.
- Үүнээс төмөр замаар 24.5 сая ачаа тээвэрлэсний 15.5 сая нь, авто замаар 63.0 сая тонн ачаа тээвэрлэсний 59.5 сая нь уул уурхайн бүтээгдэхүүн байна.
- Нийт ачаа тээврийн 86 хувь нь уул уурхайн бүтээгдэхүүн байна.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

(жуулчдын тоо, мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 2024 оны эхний 10 сарын байдлаар 651 мянгад хүрч, өмнөх оны мөн үеэс 22 хувиар нэмэгдсэн байна.

2.1 ГАДААД ХУДАЛДАА

2024.10 сар

2024 оны эхний 10 сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 22.8 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 3.6 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

ЭКСПОРТ
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 2024 оны эхний 10 сард 13,207 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар өслөө.
- Нийт экспортын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 59 хувийг бүрдүүлж байна.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ *(сая ам.доллар)*



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспортын орлого 7,418 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар өслөө.
- Зэсийн баяжмалын экспортын орлого 2,616 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 793 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 24.1 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 493 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 35.6 хувиар өслөө.

ИМПОРТ
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2024 оны эхний 10 сард импорт 9,597 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 26.7 хувиар өссөн байна.
- Нийт импортын 18.9 хувийг тоног төхөөрөмж, 16.6 хувийг нефть, 9.4 хувийг автомашин эзэлж байна.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ *(сая ам.доллар)*



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Тоног төхөөрөмжийн импорт 1,817 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 34.1 хувиар өслөө.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 1,591 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 23.4 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 900 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 58.8 хувиар өслөө.

2.2 УУЛ УУРХАЙН ЭКСПОРТ

2024.10 сар

2024 оны эхний 10 сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 93 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 80 хувийг бүрдүүллээ.

НҮҮРС
(сая тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспорт 2024 эхний 10 сард 68.5 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 26.0 хувиар өслөө.
- Гашуунсухайт боомтоор 33.0 сая тонн, Шивээхүрэн боомтоор 20.4 сая тонн, Ханги боомтоор 1.8 сая тонн, бусад боомтуудаар 13.3 сая тонн нүүрс тус тус экспортолсон байна.

ЗЭСИЙН БАЯМЖАЛ
(мян. тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Зэсийн баяжмалын экспорт 2024 эхний 10 сард 1,358 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өслөө.
- Гашуунсухайт (Оюу Толгой) боомтоор 843 мянган тонн, Замын-Үүд (Эрдэнэт) боомтоор 515 мянган тонн зэсийн баяжмал тус тус экспортолсон байна.

ТӨМРИЙН ХҮДЭР
(мян. тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Төмрийн хүдрийн экспорт 2024 эхний 10 сард 6,078 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 28.6 хувиар өслөө.
- Замын-Үүд боомтоор 5,526 мянган тонн, Бургастай боомтоор 490 мянган тонн, бусад боомтуудаар 62 мянган тонн төмрийн хүдэр тус тус экспортолсон байна.

ГАЗРЫН ТОС
(мян. баррель)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Газрын тосны экспорт 2024 оны эхний 10 сард 3,418 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар буурлаа.
- Баянхошуу боомтоор 3,136 мянган баррель, Замын-Үүд боомтоор 282 мянган баррель газрын тос тус тус экспортолсон байна.

2.3 ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭКСПОРТ

2024.10 сар

2024 оны эхний 10 сарын байдлаар голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.

МАЛЫН МАХ
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Малын махны экспорт 2024 оны эхний 10 сард 198 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 19 хувиар буурлаа.
- Тэр дундаа боловсруулсан махны экспорт өмнөх оны мөн үеэс 3 дахин багассан байна.

АРЬС ШИР
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Боловсруулсан арьс ширний экспорт 2024 оны эхний 10 сард 1.8 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 18 хувиар буурлаа.

НООЛУУР
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Ноолуурын экспорт 2024 оны эхний 10 сард 304 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8 хувиар буурлаа.

НООС
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Ноосны экспорт 2024 оны эхний 10 сард 4.2 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 17 хувиар буурлаа.

ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

($/тонн, Сингапурын бирждэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)

Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж *(SGX)* дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2024 оны 10 дугаар сарын дундаж үнэ 210 ам.долларт хүрч, өмнөх сараас 14 хувиар өссөн хэдий ч өмнөх оны мөн үеэс 41 хувиар буурсан байна.

ЗЭС

($/тонн , Лондоны металлын бирждэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

- Лондоны металлын бирж *(LME)* дэх цэвэр зэсийн үнэ 2024 оны 10 дугаар сарын дунджаар 9,539 ам.доллар хүрч, өмнөх сараас 3 хувиар, өмнөх оны мөн үеэс 20 хувиар өссөн байна.

ТӨМРИЙН БАЯЖМАЛ

($/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2024 оны 10 дугаар сарын дундаж үнэ 105 ам.долларт хүрч, өмнөх сараас 12 хувиар өссөн хэдий ч өмнөх оны мөн үеэс 12 хувиар буурсан байна.

ГАЗРЫН ТОС

($/баррель, Брент)



Эх сурвалж: Блүүмберг

- Брент газрын тосны 2024 оны 10 дугаар сарын дундаж үнэ 75 ам.долларт хүрч өмнөх сараас 4 хувиар өссөн хэдий ч өмнөх оны мөн үеэс 7 хувиар буурлаа.

4. УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА 2024.10 сар

Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2023 оны 1 дугаар сараас 2024 оны 10 дугаар сарын хооронд нийт 34.8 сая тонн нүүрс, 2.7 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 5.4 мянган тонн зэсийн баяжмал, 15.4 мянган тонн жоншны хүдэр болон баяжмалыг тус тус арилжаалаад байна.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА
(сая тонн)



Эх сурвалж Монголын хөрөнгийн биржс

- 2024 оны 10 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 34.8 сая тонн нүүрс арилжиж, 4.4 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2024 оны эхний 10 дугаар 19.9 сая тонн нүүрс арилжиж, 2.3 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2024 оны 10 дугаар сард 2.1 сая тонн нүүрс борлуулаа.

НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ
(ам.доллар/тонн)



Эх сурвалж Монголын хөрөнгийн биржс

- 2024 оны 10 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 119 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 123 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 10 дугаар сард хэлцлийн доод үнэ 27 ам.доллар, дээд үнэ 167 ам.долларт хүрэв.

ТӨМРИЙН АРИЛЖАА
(мянган тонн)

Эх сурвалж Монголын хөрөнгийн биржс

- 2024 оны 10 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дугаар сараас хойш нийт 2.7 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 197.5 сая ам.долларын орлого олжээ
- Үүнээс 2024 оны эхний 10 сард 2.0 сая тонн төмрийг арилжаалж, 140.6 сая ам.долларын орлого олжээ.

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ
(ам.доллар/тонн)



Эх сурвалж Монголын хөрөнгийн биржс

- Төмрийн хүдэр болон баяжмалын 10 дугаар сарын дуудах дундаж үнэ 66 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 69 ам.доллар болж өсөв.
- Төмрийн төрлөөс хамааран 10 дугаар сард хэлцлийн доод үнэ 64 ам.доллар, дээд үнэ 85 ам.долларт хүрэв.

5. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ

2024.09-10 сар

Төлбөрийн тэнцлийн алдагдал 2024 оны 9 дүгээр сард тэлж, гадаад валютын улсын нөөц 2024 оны 10 дугаар сарын эцэст 4.7 тэрбум ам.доллар байна.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

(сая ам.доллар)



Тэмдэглэл: Төлбөрийн тэнцлийн статистик 1 сарын хоцрогдолтой зарлагддаг.

Эх сурвалж: Монголбанк

- Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 9 сард 251 сая ам.долларын алдагдалтай гарч, тэнцэл өмнөх оны мөн үеэс 1.0 тэрбум ам.долларoор муудлаа.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 0.7 тэрбум ам.долларoор нэмэгдсэн ч импортын өсөлт 2.0 тэрбум ам.долларт хүрснээр урсгал данс алдагдалтай гарлаа.
- Төлбөрийн тэнцлийн шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал* 2024 оны эхний 9 сард 2.0 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 575 сая ам.долларoор өссөн байна.

**Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын бүцаалт болон зээлийн эргэн төлөлтэй холбоотой гарах урсгалыг хассан дүн*

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ

(сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

- Гадаад валютын улсын нөөц 2024 оны 10 дугаар сарын эцэст 4,701 сая ам.доллар болж, өмнөх сараас 39 сая ам.долларoор, өмнөх оны мөн үеэс 0.7 тэрбум ам.долларoор тус тус өслөө.

ХАНШИЙН ӨДРИЙН ӨӨРЧЛӨЛТ

(төгрөг/ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

- Төгрөгийн ам.долларт харьцах ханш 2024 оны 10 дугаар сард өдөрт дундажаар 1.1 төгрөгөөр суларснаар сарын эцэст 3,405 төгрөгт хүрлээ.
- Энэ нь оны эхнээс 6 төгрөгөөр буюу 0.2 хувиар чангарсан үзүүлэлт байна.

ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА

(сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

- Төв банк 2024 оны 10 дугаар сард 799 сая ам.долларыг, 2024 оны эхний 10 сард нийт 5,406 сая ам.долларыг валютын зах зээлд нийлүүллээ.
- Энэ нь 2023 оны мөн үеэс 62.3 хувиар буюу 2,076 сая ам.долларoор өндөр дүн байна.

6.1 ИНФЛЯЦ

2024.10 сар

Инфляц 2024 оны 10 дугаар сард 7.0 хувьд хүрч, өмнөх сараас 0.3 нэгж хувиар эрчимжлээ. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад 0.5 хувиар өссөн байна.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ
(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Инфляц 2024 оны 10 дугаар сард улсын хэмжээнд 7.0 хувьд гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.3 нэгж хувь (32.8%)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 4.7 нэгж хувь буюу 67.2 хувийг эзэлж байна.

САРЫН ИНФЛЯЦ
(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- 2024 оны 10 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.5 хувиар өсөв.
- Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.5 хувиар өсөхөд хувцас, гутлын үнэ 1.7 хувиар, орон сууцны түрээс 7.7 хувиар, автомашины үнэ 4.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.
- Хүнсний барааны үнэ өмнөх сараас 0.2 хувиар буурчээ.

СУУРЬ ИНФЛЯЦ
(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2024 оны 10 дугаар сард суурь инфляц 7.2 хувь гарч, нийт инфляцын 4.8 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 4 сар өсөлөө.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ *(хувь)*



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2024 оны 10 дугаар сард жилийн инфляцын 21 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар өсжээ.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өсөв.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар өслөө.

6.2 ИНФЛЯЦ

2024.10 сар

Олон улсад чингэлэг тээврийн үнэ өндөр байгаа нь импортын инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна. Хүнсний үнийн индекс 2024 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ХҮНСНИЙ БА ХҮНСНИЙ БУС ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Хүнсний инфляц 2024 оны 10 дугаар сард 7.7 хувь болж, нийт инфляцын 2.2 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хүнсний бус инфляц 6.5 хувь болж, нийт инфляцын 4.8 нэгж хувийг бүрдүүллээ.

ИМПОРТЫН ИНФЛЯЦ БА ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Монголбанк

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2024 оны 10 дугаар сард дунджаар 3,392 төгрөг болж, өмнөх сараас 0.3 хувиар сулрав.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ өмнөх сараас 0.8 хувиар өссөн байна.

ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ҮНЭ

(1000$/40 фут контейнер)



Эх сурвалж: Drewry World Container Index

- Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис/Суэцийн сувагт үүссэд буй халдлагаас үүдэлтэйгээр өсөөд байна.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2024 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 3,444 ам.доллар буюу өмнөх оны мөн үеэс 129 хувиар өндөр байна. Энэ нь цар тахлаас өмнөх 2019 оны дундаж үеэс 142 хувиар өндөр үзүүлэлт юм.
- Чингэлэг тээврийн үнэ 7 дугаар сараас эхлэн буурч эхэлсэн боловч өмнөх онтой харьцуулахад өндөр хэвээр байгаа нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна.

ХҮНСНИЙ ҮНИЙН ИНДЕКС

(хувь)



Эх сурвалж: FAO

- НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс нь хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2024 оны 10 дугаар сард 127.4 болж, өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар, өмнөх сараас 2 хувиар тус тус өссөн байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээр элсэн чихэр, үр тариа, ургамлын тос, сүүн бүтээгдэхүүний үнэ өссөн бол махны үнэ буурчээ.

7. ТӨСӨВ

2024.10 сар

Монгол Улсын нэгдсэн төсөв 2024 оны 10 дугаар сарын байдлаар 1.5 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон НӨАТ өссөн нь төсвийн орлого нэмэгдэхэд нь голлон нөлөөллөө.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ

(их наяд төгрөг)

Эх сурвалж: Сангийн яам

- Нэгдсэн төсөв 2024 оны эхний 10 сард 1.5 их наяд төгрөгийн ашигтай гарч, ашиг өмнөх оны мөн үеэс 538 тэрбум төгрөг буюу 26.1 хувиар буурсан байна.

ТӨСВИЙН ОРЛОГО

(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Орлого 2024 оны 10 дугаар сарын байдлаар 25.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.7 их наяд төгрөг буюу 28.7 хувиар нэмэгдсэн байна.
- Дээрх өсөлтөд орлогын албан татвар 2.4 их наяд төгрөг буюу 47.9 хувиар, НӨАТ 861.3 тэрбум төгрөг буюу 22.8 хувиар, нийгмийн даатгалын орлого 672.6 тэрбум төгрөг буюу 22.8 хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн ч АМНАТ 295.3 тэрбум төгрөг буюу 8.1 хувиар буурсан байна.

2024 ОНД НЭМЭГДСЭН ГОЛЛОХ ЗАРЛАГУУД

(зарлагын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Зарлага 2024 оны 10 дүгээр сарын байдлаар 22.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.4 их наяд төгрөг буюу 32.2 хувиар нэмэгдсэн байна.
- 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс цалин, тэтгэврийг дунджаар 10 хувиар нэмэгдүүлсэн.
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудал, эдийн засгийн суурийг тэлэх эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг эхлүүлэхээр төлөвлөж, 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдүүлээд байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(их наяд төгрөг, ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Сангийн яам

- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 30.8 их наяд төгрөгт хүрч, ДНБ-д харьцуулсан харьцаа 38.9 хувьд хүрээд байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.

8. МӨНГӨ, САНХҮҮ

2024.10 сар

Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 10 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 25.1 хувиар өсөж, 42.2 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2024 оны 10 дугаар сард 34.6 хувиар өссөн байна.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ *(жилийн өсөлт, хувь)*



Эх сурвалж: Монголбанк

- Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 10 дугаар сарын эцэст 42.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 25.1 хувиар өссөн байна.
- Төгрөгийн хадгламж нийт өсөлтийн 16.1 нэгж хувь, төгрөгийн харилцах 7.8 нэгж хувь, хадгламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.3 нэгж хувь, гадаад валютын харилцах 2.2 нэгж хувь, гадаад валютын хадгламж -1.3 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.

ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ *(жилийн өсөлт, хувь)*



Эх сурвалж: Монголбанк

- Нийт хадгламж 25.2 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгламж 20.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 35.3 хувиар, өмнөх сараас 0.8 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгламж 4.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар, өмнөх сараас 0.1 хувиар тус тус буурлаа.

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ *(хувь)*



Эх сурвалж: Монголбанк

- Банкнуудын зээлийн үлдэгдэл 2024 оны 10 дүгээр сарын эцэст 35.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 34.6 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.5 нэгж хувиар буурсан байна.

ХҮҮГИЙН ТҮВШИН *(жигнэсэн дундаж хувь)*



Эх сурвалж: Монголбанк

- Банкнуудын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 10 дугаар сард 17.0 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өслөө.
- Банкнуудын шинээр татсан хадгламжийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 10 дугаар сард 12.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар, өмнөх сараас 0.5 нэгж хувиар өслөө.

9.1 ХӨДӨЛМӨР

2024 оны 3 дугаар улирал

Цар тахлын нөлөөгөөр буураад байсан хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр сэргэж, цар тахлын өмнөх түвшнийг давлаа. 2024 оны 3 дугаар улиралд ажилчдын тоо 1,360 мянга болж, ажиллах хүчний оролцооны түвшин 63.0 хувьд хүрэв.

АЖИЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ХҮЙСЭЭР *(мянган хүн, хувь)*



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 34 мянга буюу 3 хувиар нэмэгдэж 1,360.3 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 72.4 мянгаар өндөр үзүүлэлт юм.
- 2024 оны 3 дугаар улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 13.9 мянгаар, эмэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 20.2 мянгаар тус тус өссөн байна.

АЖИЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, САЛБАРААР *(мянган хүн)*

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Ажилчдын тооны өсөлтөд үйлчилгээ ба бусад, худалдаа, тээвэр, уул уурхай, барилгын салбарын ажилчид нэмэгдсэн нь эергээр нөлөөлсөн байна.
- Харин өөлжилтийн нөхцөл байдал хүндэрсний улмаас хөдөө аж ахуйн салбарын ажилчид, мөн боловсруулах, ус, цахилгааны салбарын ажилчдын тоо буурсан нь сөргөөр нөлөөллөө.

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН *(хувь)*



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Ажиллах хүчний оролцооны түвшин 63.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар, цар тахлын өмнөх үеэс 2.9 нэгж хувиар өслөө.
- Харин ажилгүй иргэдийн тоо 2024 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 14 мянган хүнээр өсөж 82.3 мянгад хүрсэн байна. Ингэснээр ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар өсөж 6.1 хувьд хүрчээ.

МЕДИАН ЦАЛИН, ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ *(хувь)*



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Дундаж цалингийн хэмжээ 2024 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар өсөж, 2 сая 465 мянган төгрөгт хүрлээ.
- Улсын медиан цалин 2024 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 41.2 хувиар өсөж, 2 сая 27 мянган төгрөг болов. Энэ нь дундаж цалингаас 438 мянган төгрөгөөр бага байна.
- Салбараар авч үзвэл уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж улсын дунджаас 2 дахин өндөр байна.

9.2 ӨРХИЙН ОРЛОГО

2024 оны 3 дугаар улирал

Өрхийн нэрлэсэн дундаж орлого 2.6 сая төгрөг боллоо. Орлого багатай, цалингийн орлогогүй иргэдийн бодит орлого буурах эрсдэлтэй байна.

ӨРХИЙН БОДИТ ОРЛОГЫН ӨСӨЛТ
(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Өрхийн бодит орлого 10 хувиар өсөж, өсөлт суурийн нөлөөгөөр саарлаа.
- Өсөлтөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс 234 мянган төгрөгөөр, ХААН орлого 87 мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 69 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлөв.

НЭРЛЭСЭН ОРЛОГО
(сая ₮)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Өрхийн дундаж бодит орлогод эзлэх цалингийн хэмжээ 55.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар нэмэгдсэн байна.
- Үүнд дундаж цалингийн өсөлтөөс гадна хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн нь нөлөөлж байна.

ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО
(сая төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бага орлоготой өрхийн дундаж орлогод өсөлт төдийлөн ажиглагдахгүй байна.
- Нийт өрхийн 35.7 хувийг 1.6 сая төгрөгөөс бага орлоготой өрхүүд бүрдүүлж байгаа ба тэдгээрийн сарын дундаж орлого нэрлэсэн дүнгээр 967 мянган төгрөг байна.
- Харин 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого 3,278 мянган төгрөг байна.

ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО
(сая ₮)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Нийслэлийн өрхийн дундаж орлого 3 сая төгрөгт хүрсэн бол хөдөө орон нутгийн өрхийн орлого бага байна.
- Цалингийн орлого нийслэлийн өрхийн орлогын 61.2 хувийг бүрдүүлж байгаа бол хөдөөгийн өрхийн орлогын 18.7 хувийг бүрдүүлж байна.

10.1 ГАДААД ЭДИЙН ЗАСАГ - ОХУ

2024.10 сар

ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 3.1 хувь байна. Төв банкнаас бодлогын хүүг 2024 оны 10 дугаар сард 2 нэгж хувиар өсгөж, 21 хувьд хүргэв. Харин инфляцын түвшин 2024 оны 10 дугаар сард 8.5 хувьд хүрч, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурлаа.

БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ

(хувь)



Эх сурвалж: Блүүмберг

- ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 3 дугаар улиралд 3.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар буурлаа.
- Цэрэг, армийн зардлын өсөлттэй холбоотой төсвийн зардал тэлэлтээс үүдэн идэвхжээд байсан эдийн засгийн өсөлт ийнхүү саарч, 2023 оны эхний улирлаас хойш доод үзүүлэлтэд хүрлээ.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Блүүмберг

- Экспорт 2024 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 3.9 хувиар, өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар тус тус өслөө.
- Импорт 2024 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 10 хувиар, өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар тус тус өслөө.
- Экспортын өсөлтөд Оросын экспортын гол нэрийн барааны дэлхийн үнийн өсөлт голлон нөлөөлсөн. Импортын өсөлт нь барааны биет хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой.

ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Блүүмберг

- Инфляцын түвшин 2024 оны 10 дугаар сард 8.5 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурсан байна. ОХУ-ын инфляц сүүлийн 2 сар дараалан буурлаа.
- ОХУ-ын инфляц зорилтот түвшин 4 хувиас өндөр хэвээр байна.
- ОХУ-ын Төв банкнаас 10 дугаар сарын 25-ны өдөр бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 21 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)

(нэгж, хувь)



Эх сурвалж: Блүүмберг

- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2024 оны 10 дугаар сард 50.6 болж, өмнөх сараас 1.1 нэгжээр өслөө.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2024 оны 9 дүгээр сарын байдлаар 3.2 хувь болж, өмнөх сараас 0.5 нэгж хувиар өслөө.

10.2 ГАДААД ЭДИЙН ЗАСАГ - БНХАУ

2024.10 сар

БНХАУ-ын эдийн засгийн 2024 оны эхний 3 улирлын өсөлт 4.8 хувьд байна. Экспорт 2024 оны 10 дугаар сард 12.7 хувиар буюу 2023 оны 3 сараас хойших хамгийн өндөр хувиар өссөн бол жижиглэнгийн худалдааны өсөлт өмнөх сараас 1.6 хувиар эрчимжлээ.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ *(хувь)*



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- БНХАУ-ын эдийн засаг 2024 оны 3 дугаар улиралд 4.6 хувиар өссөнөөр эхний 3 улирлын өсөлт 4.8 хувьд хүрлээ.
- Экспортын өсөлт 2024 оны 10 дугаар сард 12.7 хувь болж, 2023 оны 3 сараас хойших хамгийн их хувиар тэллээ.
- Импорт 2024 оны 9 дүгээр сард 0.3 хувиар өссөн бол 2024 оны 10 дугаар сард 2.3 хувиар агшлаа.

АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ *(хувь)*



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн гарцын өсөлт 2024 оны 10 дугаар сард 5.3 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар саарсан бол жижиглэн худалдааны өсөлт өмнөх сараас 1.6 нэгж хувиар эрчимжиж, 4.8 хувьд хүрлээ.

ИНФЛЯЦ *(хувь)*

Эх сурвалж: Блүүмберг

- Хэрэглээний үнийн индексийн өсөлт 2024 оны 10 дугаар сард 0.3 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурлаа.
- Харин үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2024 оны 10 дугаар сард өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурч -2.9 хувьтай гарлаа.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) *(нэгж)*



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2024 оны 10 дугаар сард 50.1 болж, 4 дүгээр сараас хойш эхний удаа тэлэлтийг илтгэх босго утга 50-ийг давав.
- Мөн аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас тус тус 0.2 болон 0.4 нэгжээр өссөн байна.

Тус индексийн богино хугацааны идэвхжлийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог.

Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ